



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-8

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

**Аэродромын Дизайн:
Хелипортууд**

2016 оны 2 сарын 4

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

АС-д дурдсан ишлэлийн дугаар нь, жишээ нь 139.15 гэх мэт, ИНД-139 -ийн тухайн тодорхой дүрмийн заалтын ишлэл болно.

Зорилго

Энэхүү АС нь ИНБД-ийн ИНД-139 шаардлагуудтай хүн амын суурьшлын бүсэд орших хелипортын дизайн, төлөвлөлт нийцэж байгааг харуулсан, эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөх аргачлалуудыг агуулсан болно.

Хэрэглээ

Энэ материал хүн амын суурьшлын бүсэд байрших хелипортыг хэрэглэгч, ашиглагч эсхүл үйл ажиллагаа эрхлэгч / операторд / зориулагдсан болно.

Холбоотой Дүрэм

Энэ ЗЦ нь ИНД-139-той тодорхой хамааралтай болно.

Өөрчлөлтийг мэдэгдэх нь

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-139-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

ЗЦ139-8-ыг NZ АС139-8-ын 2007 оны 4 сарын 27-ны өөрчлөлт 2-д үндэслэн боловсруулсан болно.

Агуулга

Нэгдүгээр бүлэг - Ерөнхий зүйл	4
1.1. Танилцуулга.....	4
1.2. Хэлипортын байршил сонголт	4
1.3. Тодорхойлолтууд.....	4
Хоёрдугаар бүлэг - Хэлипортын өгөгдлүүд	6
2.1. Хэлипортын хэмжээсүүд болон холбоотой мэдээлэл	6
Гуравдугаар бүлэг - Бодит / физик үзүүлэлтүүд	7
3.1. Гадаргын түвшний хэлипорт	7
3.2. Өргөгдсөн түвшний хэлипорт - Ерөнхий шаардлагууд	10
3.3. Нисдэг тэрэгний тавцангууд.....	12
3.4. Хөлөг онгоц дээрх хэлипорт.....	14
Дөрөвдүгээр бүлэг - Саадыг хязгаарлах ба арилгах	14
4.1. Саадыг хязгаарлах гадаргуу ба сектор	14
Тавдугаар бүлэг - Ил харааны тэмдэгтүүд	19
5.1. Салхины чиглэл заагч	19
5.2. Тэмдэгт ба тэмдэглэгээ - Хэлипортыг таних будган тэмдэглэгээ	19
5.3. Гэрлүүд - Салхи заагч	26
Зургадугаар бүлэг - Эмнэлгийн хелипорт	31
6.1. Аюулгүй бүс	31
Хавсралт 1	32

Нэгдүгээр бүлэг - Ерөнхий зүйл

1.1. Танилцуулга

1.1.1 Энэ ЗЦ нь хүн амын суурьшлын бүсүүдэд байршсан хэлипортын хүлээн зөвшөөрөхүйц төлөвлөлтийн шаардлагуудыг агуулсан болно. Энэ ЗЦ бүрэн төгс, бүгдийг хамарсан баримт бичиг биш ба нэмэлт дэлгэрэнгүй шаардлагуудыг “ИКАО Аннекс 14, Боть 2 , Хэлипортууд” -аас авч болно.

1.1.2 Газардах болон хөөрөх бүс - (TLOF) / цаашид ГХБ гэх / ба түүнтэй холбоотой элементүүдийн ажиллагаа нь нисдэг тэрэг аюулгүй үр дүнтэй газардах болон хөөрөлт үйлдэхэд чухал ач холбогдолтой юм. Тэдгээр гадаргуугийн төлөвлөлтийг тухайн хэлипортыг ашиглах, хэрэглэх нисдэг тэрэгний үйл ажиллагааны болон физик бодит үзүүлэлтийг харгалзан тооцно.

1.2. Хэлипортын байршил сонголт

1.2.1 Хэлипортын төлөвлөлт, байршил нь хөндлөн салхитай үеийн буулт хөөрөлт минимум хэмжээнд ба арын салхитай үед буулт хөөрөлт үйлдэхгүй байхаар тооцно. Хэлипортын зөв байршил нь хоорондоо 180 градусын зайтай, хоёр ойртолтын чиглэлтэй, нэг талын ойртолт ноёлох салхины эсрэг чиглэлд ашиглалтын хувь хэмжээ хүлээн зөвшөөрөхүйц байна.

1.2.2 Барилга эсхүл бусад саадууд 180 градусын зайтай ойртолтын чиглэлийг боломжгүй болгосон тохиолдолд 90 градусаас багагүй зайтай байхаар тооцно.

1.2.3 Хэрэв тухайн хэлипорт 1-р ангиллын үзүүлэлттэй нисдэг тэрэгнээс өөр нисдэг тэрэг ашиглахаар бол газар дээрх аливаа хүн эсхүл өмч хөрөнгөд аливаа зохисгүй эрсдэл үзүүлэлгүй хөөрөлт ба ойртолтын траекторыг оруулан орох гарах маршрутаар онцгой нөхцлийн үеийн буултыг хэзээ ч үйлдэх боломжтой байхаар байршсан байна.

1.3. Тодорхойлолтууд

Шүргэх цэг гэж ГХБ рүү орохоос өмнө тухайн цэг рүү нисгэгч сүүлийн ойртолт хийх БХБ -ийн гадаргуу дээр тэмдэглэгдсэн гурвалжин тэмдэглэгээг хэлнэ.

Агаараар явгалах зам гэж нисдэг тэрэгний агаараар явгалахад зориулан бэлтгэгдсэн газрын гадарга дээрхи тодорхойлсон траекторыг хэлнэ.

Ойртолт гэж онгоц аливаа зүйлийг ачаалах эсхүл хүмүүсийг суулгах эсхүл буулгах эсхүл ачаа буулгахаар доошлох эсхүл буулт үйлдэж болох цэг рүү журмын дагуу шилжихдээ үйлдэх хэд хэдэн урьдчилсан тогтоосон маневруудыг хэлнэ.

Өргөгдсөн нисдэг тэрэгний талбай. Газраас дээш өргөгдсөн бүтээц дээр байрлах хэлипорт.

Буулт хөөрөлтийн бүс. (БХБ) гэж дээр нь буулт хийх эсхүл дүүжин нислэг хийхээр ойртолтын үйлдлийн сүүлийн үе шатыг гүйцэтгэх ба хөөрөх үйлдэл эхлэх тодорхойлсон хэсэг газар. 1-р ангиллын үзүүлэлт бүхий нисдэг тэрэг ашиглах тохиолдолд тухайн бүс нь хөөрөлтийг зогсоох хэсгийг дотроо агуулдаг гэж үздэг.

Нисдэг тэрэгний тавцан / Helideck / - усанд хөвөгч эсхүл бэхлэгдсэн тусдаа бүтээц дээр байрлах хэлипорт.

Хэлипорт гэж нисдэг тэрэг хөөрөх, буух, газрын хөдөлгөөн үйлдэхэд бүтнээр нь эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулагдсан аэродром эсхүл бүтээц дээрхи тодорхойлсон талбай.

Саадаас хязгаарлах гадаргуу гэж саадаас чөлөөтэй ойртолтын болон хөөрөлтийн өндөр авах гадаргууг үнэлэх, тогтооход хэрэглэх нисдэг тэрэгний нислэгийн үзүүлэлттэй тохирсон өнцгөөр БХБ -ээс эсхүл аюулгүй бүсээс гадагшаа болон дээшээ чиглэлтэй өргөгсгөсөн орон зайн гадаргуунууд юм.

Нисдэг тэрэгний нийт урт гэж сэнснүүдийг оролцуулаад онгоцны хитэг болон нүүрэн хэсгийн дагуу хэмжсэн нисдэг тэрэгний хамгийн их уртыг хэлнэ.

Нисдэг тэрэгний нийт өргөн гэж гол сэнсний диаметрийг хэлнэ.

1-р ангиллын үзүүлэлттэй нисдэг тэрэг гэж хөдөлгүүрт гэмтэл тохиолдоход хөөрөлтийг зогсоосон талбайд буулт үйлдэх боломжтой эсхүл тохиромжтой буух талбай руу нислэгээ үргэлжлүүлэх боломжтой үзүүлэлттэй нисдэг тэрэг юм.

Аюулгүй бүс гэж агаарын навигацийн зориулалтаар шаардсанаас бусад саадаас чөлөөтэй, БХБ -ээс ослын шалтгаанаар хазайсан нисдэг тэрэгт учрах эвдрэл, гэмтлийн эрсдлийг багасгах бууруулахад зориулагдсан, БХБ -ийг тойрсон хэлипорт дахь тогтоосон талбай. Энэ талбай нь нисдэг тэрэгний жинг даах чадвартай байна.

Гадаргын түвшний нисдэг тэрэгний талбай гэж газрын гадарга дээр эсхүл усан дээр байрлах хэлипортыг хэлнэ.

Газардах болон хөөрөх бүс (ГХБ) гэж нисдэг тэрэг газардаж эсхүл хөөрч болох ачаалал даах чадвартай талбайг хэлнэ.

Хоёрдугаар бүлэг - Хэлипортын өгөгдлүүд

2.1. Хэлипортын хэмжээсүүд ба холбоотой мэдээлэл

Хэлипорт ашиглагчдад зарлан мэдээлэх шаардлагатай бол байгууламж тус бүрд тохирсон дараахи мэдээллүүдийг хэмжсэн эсхүл тайлбарласан байна.

- (a) Хэлипортын төрөл - гадаргын түвшний, өргөгдсөн нисдэг тэрэгний тавцан;
- (b) Газардах болон хөөрөх бүсийн (ГХБ) - хэмжээнүүд, налуу, гадаргуугын төрөл, даацыг тонноор илэрхийлсэн хэмжээ / 1000 кг /;
- (c) БХБ-ийн - урт, өргөн, налуу, гадаргын төрөл
- (d) Аюулгүй бүс - урт, өргөн, гадаргын төрөл
- (e) Нисдэг тэрэгний агаараар явгалах замын чиглэл, өргөн, гадаргын төрөл
- (f) Перрон - гадаргын төрөл
- (g) Хэлипорт дээр болон түүний орчимд байх мэдэгдэхүйц саадууд - байршил, хамгийн өндөр цэгийн өндөржилт метрээр, төрөл
- (h) Ойртолтын журмын ил харааны тоноглолууд, БХБ, ГХБ, явгалах замууд, перроны будган тэмдэглэгээ, болон гэрлүүд
- (i) Аливаа салхи заагчийн байршил ба гэрэлтэй эсэх

Гуравдугаар бүлэг - Бодит / физик үзүүлэлтүүд

3.1. Гадаргын түвшний хэлипорт

- Буулт хөөрөлтийн бүс (БХБ)

3.1.1 Гадаргын түвшний хэлипорт нь хамгийн багадаа нэг буулт хөөрөлтийн бүстэй байна.

3.1.2 БХБ -ийн хэмжээсүүд тухайн хэлипортыг ашиглахаар төлөвлөсөн хамгийн урт эсхүл өргөн нисдэг тэрэгний нийт урт эсхүл өргөний их хэмжээнээс нь 1.5 дахин их хэмжээнээс багагүй диаметр бүхий тойрог зурж багтаахад хангалттай дүрс хэмжээтэй байна.

3.1.3 БХБ дээрх хэвтээ гадаргуугаас дээш аль ч чиглэлд гадаргын нийт налуу 3 % -иас хэтрэхгүй байна. Налуу өөрчлөгдсөн доторх хэрчим 5 %-иас хэтрэхгүй налуутай байна.

3.1.4 Гадаргын түвшний хэлипортын БХБ-ийн гадаргуу нь нисдэг тэрэгний сэнсний эргэлтээс доош нөлөөлөх урсгалд тэсвэртэй байна.

3.1.5 Хөдөлгөөн үйлдэж байгаа нисдэг тэрэгний үйл ажиллагаанд саад болох аливаа саад БХБ дээр байхыг хориглоно.

- БХБ-ийн хоорондын зайчлал

3.1.6 БХБ-үүдийн хоорондын хамгийн бага зай нь тухайн БХБ дээр нислэг үйлддэг хамгийн том нисдэг тэрэгний сэнсний диаметртээс багагүй байна.

- Газардах болон Хөөрөх Бүс / ГХБ/

3.1.7 Хелипорт нь хамгийн багадаа нэг ширхэг газардах болон хөөрөх бүстэй / ГХБ / байна. Энэ нь буултын болон хөөрөлтийн бүсийн (БХБ) дотор эсхүл дотор нь биш байршиж болно.

3.1.8 Газардах болон хөөрөх бүс / ГХБ / тухайн хелипортыг ашиглах хамгийн том нисдэг тэрэгний хөл ангийн урт эсхүл өргөний хэмжээний аль ихээс нь 1.5 дахин илүү хэмжээний диаметртэй тойрог багтаах хангалттай хэмжээтэй байна.

3.1.9 ГХБ нь тухайн хэлипортод үйл ажиллагаа явуулах нисдэг тэрэгний нислэгийн зааварт заагдсан түвшинд эсхүл хэрэв налуугүй байх боломжгүй бол налуугийн хязгаарлалтаас хэтрэхгүй налуутай байвал тохиромжтой.

3.1.10 Хэрэв ГХБ нь БХБ дээр байрлаагүй нөхцөлд аливаа суурилагдсан саадаас / барилга байгууламж, ангар, шон зэрэг / сэнсний диаметрийн хагасаас багагүй хэвтээ гол сэнсний минимум зайчлалыг хангахаар зайтай байрлана.

- ГХБ хоорондын зайчлал

3.1.11 ГХБ нь ашиглаж буй хамгийн том нисдэг тэрэгний нийт жинг 2 дахин ихэсгэсэн хэмжээний ачааллыг даах хангалттай даацтай байна.

3.1.12 ГХБ-н гадаргуу тухайн талбайг ашиглаж буй нисдэг тэрэг болон хүмүүсийн хөдөлгөөнд аюулгүй, хальтиргаа гулгаагүй байна.

3.1.13 Хэрэв БХБ дээр нэгээс олон тооны ГХБ байгаа бол тэдгээрийн хоорондын зай нь аль ч ГХБ-г ашиглах хамгийн том нисдэг тэрэгний том сэнсний диаметрийн хэмжээнээс багагүй хэмжээтэй байна.

- Аюулгүй бүсүүд

3.1.14 БХБ нь аюулгүй бүсээр хүрээлэгдсэн байна.

3.1.15 Аюулгүй бүс БХБ-ны гадна захаас гадагш 3 м эсхүл тухайн хэлипортыг ашиглах хамгийн урт эсхүл өргөн нисдэг тэрэгний нийт урт эсхүл өргөний хэмжээний аль уртын 25%-иас багагүй зайнд үргэлжилнэ.

3.1.16 Тэдгээрийн үйл ажиллагаанаас шалтгаалан аюулгүй бүсэд байрлах шаардлагатай, хэврэг суурилагдсан объектоос бусад хөдөлгөөнгүй объектийг аюулгүй бүсэд байрлуулахыг хориглоно. Мөн нисдэг тэрэг бууж хөөрөх үед аюулгүй бүсэд хөдөлгөөнтэй объект байрлуулахыг хориглоно.

3.1.17 Аюулгүй бүсэд байрлуулах шаардлагатай объект нь БХБ-ны ирмэгийн дагуу байрласан бол 250 мм-ээс ихгүй өндөртэй, харин аюулгүй бүсэд байрласан биетүүд нь БХБ-ны ирмэгээс дээш 250 мм-ийн өндөрт эхлэлтэй гадаргууг ба БХБ-н хязгаараас дээшээ болон гадагшаа 5%-ийн налуутай хавтгайг нэвтрэхгүй байна.

3.1.18 Аюулгүй бүсийн гадаргуу БХБ-н хязгаараас гадагш 4%-оос ихгүй налуугаар өгссөн байж болно.

- Зогсох талбай

3.1.19 Нисдэг тэрэгний зогсоолууд ашиглаж буй нисдэг тэрэгнүүдийг багтаах тооны байна. БХБ эсхүл ГХБ -д бусад нисдэг тэрэг буух, хөөрөх боломжгүй болгох тул зогсох нисдэг тэрэгний тоо аль болох цөөн байхаар хэмжээнд нь тааруулан төлөвлөсөн байна.

3.1.20 Хэлипортын ашиглалтыг сайжруулах зорилгоор зогсоолын талбай ойртолтын болон хөөрөлтийн гадаргуугаас чанад, зэргэлдээ байх аливаа суурилагдсан эсхүл хөдөлгөж болох объектоос нисдэг тэрэгний том сэнсний диаметрийн 1/3-ээс багагүй зайтай байна.

- Агаараар явгалах зам

3.1.21 БХБ дээр байрлаагүй ГХБ-д очих зорилгоор нисдэг тэрэг агаараар хөдөлгөөн үйлдэх агаараар явгалах замыг тогтоож, бэлтгэсэн байна.

3.1.22 Агаараар явгалах замын өргөн нь хамгийн багадаа тухайн агаараар явгалах замыг ашиглах нисдэг тэрэгний нийт өргөний хэмжээнээс хоёр дахин өргөн хэмжээтэй байна.

3.1.23 Агаараар явгалах замын гадаргуу нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

(а) нисдэг тэрэгний сэнсний эргэлтийн нөлөөгөөр бий болох агаарын урсгалд тэсвэртэй байх,

(b) онцгой байдлын үед суулт үйлдэхэд тохиромжтой байх,

(c) газрын нөлөөг хангаж байх

3.1.24 Агаараар явгалах зам ба өөр агаараар явгалах зам, агаараар явгалах зам ба саад эсхүл агаараар явгалах зам ба ГХБ-ны хоорондын зай хүснэгт 3-1-д үзүүлсэн холбогдох хэмжээнээс багагүй байна.

Хүснэгт 3-1. Нисдэг тэрэгний агаараар явгалах замын зайчлал

Агаараар явгалах зам	Саад	ГХБ
4а (тэнхлэгүүдийн хоорондын зай)	1.5а (тэнхлэгээс саад хүртэлх зай)	4а (тэнхлэгээс хязгаар хүртэлх зай)

а. Нисдэг тэрэгний том сэнсний эргэж байх үеийн нийт өргөний хэмжээ

- ХБЗ эсхүл ЯЗ-тай холбоотой БХБ-н байрлал

3.1.25 БХБ аэродромын ХБЗ эсвэл ЯЗ-ын ойролцоо байрласан бөгөөд ил харааны цаг агаарын нөхцөлд үйл ажиллагаа нэгэн зэрэг явагдахаар төлөвлөгдсөн бол ХБЗ эсвэл ЯЗ-ын хязгаар ба БХБ-ны хязгаарын хоорондын зай хүснэгт 3-2-д заасан хэмжээнээс багагүй байна.

Хүснэгт 3-2. БХБ хамгийн бага хоорондын зайнууд

Хэрэв онгоцны ба/ эсхүл нисдэг тэрэгний жин	ХБЗ эсхүл ЯЗ-ын хязгаар ба БХБ-ны хязгаарын хоорондын зай
2720 кг хүртэл гэхдээ 2720 кг -ийг оруулахгүй	60 m
2720 кг -аас дээш 5760 кг хүртэл гэхдээ 5760 кг -ийг оруулахгүй	120 m
5760 кг --аас дээш 100 000 кг хүртэл гэхдээ 100 000 кг -ийг оруулахгүй	180 m
100 000 кг ба түүнээс дээш	250 m

3.1.26 БХБ нь дараах байдлаар байрлахыг хориглоно. Үүнд:

- (a) явгалах замуудын огтлолцол эсхүл жет хөдөлгүүрээс их хэмжээний сөрөг урсгал үүсэхээс шалтгаалж ХБЗ-ны хүлээх байрлалын ойролцоо,
- (b) онгоцны хөдөлгүүрийн цоргилтын нөлөөгөөр үүсэх агаарын урсгал их хурдтай байх бүсүүдийн ойролцоо

3.2. Өргөгдсөн түвшний хэлипорт - Ерөнхий шаардлагууд

3.2.1 БХБ, ГХБ ба аюулгүй бүсийн хэмжээнүүд, налуу гэх мэт шаардлагууд газрын түвшингийн хэлипортод тавигддагтай адил байна. Талбайн гадаргуугийн хамгийн бага диаметр нь хэлипортод үйл ажиллагаа явуулдаг хамгийн урт нисдэг тэрэгний нийт уртын хэмжээнээс багагүй урттай байна.

- Даацын шаардлага

3.2.2 Өргөгдсөн түвшний хэлипортын хувьд даацын хэмжээ 3.3.8-д тодорхойлсон нисдэг тэрэгний тавцангийн даацтай ижил байна.

- Гарц

3.2.3 Хоёроос багагүй тооны гарцтай байна. Эдгээр гарцнууд хэлипортын бүсээс гадна энэ бүсийн эсрэг талд нь байрласан байх ба шатны өргөн багадаа 1000 мм хэмжээтэй, шатны бариултай байна.

3.2.4 Шатыг шатдаггүй материалаар хийсэн байх ба чөлөөтэй байлгана.

3.2.5 Шат ба шатны бариул нь саадаас чөлөөтэй гадаргуугийн оролт/гаралтын бүс рүү орохоор бол хэлипортын гадаргуугийн түвшинд хүртэл хураагдаж, эвхэгддэг, хураагдсан үедээ шатанд ямар нэгэн саад болохгүй байхаар хийгдсэн байна.

- Будгийн өнгө

3.2.6 Өргөгдсөн түвшний хэлипортыг шөнөөр ашигладаг бол шатны бариул, аюулгүй хүрээ, гишгүүрүүдийн ирмэг зэргийг өөр газраас туссан аливаа гэрэлд харагдахаар гэрэлтэй тод өнгийн будгаар будсан байна.

- Аюулгүй бүс

3.2.7 Өргөгдсөн түвшний хэлипортыг тойрсон аюулгүй бүс бүхэлдээ эсхүл хэсэгчлэн бүтээцийн хананаас гадна байж болно.


- Аюулгүйн тор

3.2.8 Хэрэв саадгүй байх бүсийн шаардлагыг зөрчих учраас хамгаалалтын хайс хийх боломжгүй бол, тавцанг тойруулж тухайн хэсгүүдэд аюулгүй тор хийсэн байна. Аюулгүй тор нь доорх шаардлагуудыг хангасан байна.

Өргөн:	Хамгийн багадаа 1500 mm
Минимум бат бөх чанар:	Тууш метр тутамд 200 кг
Налуу:	Аюулгүй тор нь БХБ -ийн гадаргуугаас доош өндөрт 1:4 хэмжээтэй гадагшаа ба өгсүүр налуутай байх ба гадна хязгаар нь ГХБ -н гадаргуугаас өндөргүй байхаар бүтээцэд бэхэлж тогтоосон байна.

3.2.9 Хэлипортыг нисдэг тэрэгний үйл ажиллагаанд ашиглахгүй байх үед аюулгүй торыг давхар хайсаар бататгаж болох ба энэ талаар зураг төсөлд оруулсан байж болно. Зураг 3-1-ийг үз. Торны хэсэг бүр хатуу хүрээтэй хийгдэж, бэхлэгдсэн байна.

Зураг 3-1. Хөдөлгөөнт эвхэгддэг тортой хамгаалалтын хашлага



3.2.10 ГХБ -н гадаргуу ба БХБ-н нисдэг тэргэнд зорчигчдыг суулгах эсхүл буулгах үед хэрэглэгдэх хэсэг гулгаагүй, хальтиргаагүй байна.

3.3. Нисдэг тэрэгний тавцангууд

Нөхөн сэргээлт, бүтээн байгуулалт, газрын тос, ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагаатай холбоотой бүтээц дээр байрласан нисдэг тэрэгний тавцанд дараах шаардлагууд тавигдана. Энэ зүйлийн 3.4 -т хөлөг онгоцны тавцан дахь хэлипортын тухай үзнэ үү.

- Буух болон хөөрөх бүс ба Газардах болон Хөөрөх бүс

Нисдэг тэрэгний тавцангийн хувьд БХБ ба ГХБ давхацсан байж болно.

3.3.1 Нисдэг тэрэгний тавцан хамгийн багадаа нэг БХБ -той байна.

3.3.2 БХБ нь ямарч хэлбэртэй байж болох ч, нэг үндсэн сэнстэй нисдэг тэрэгний эсхүл зэрэгцээ хоёр үндсэн сэнстэй нисдэг тэрэгний хувьд тухайн тавцанг ашиглах хамгийн том нисдэг тэрэгний D хэмжээнээс багагүй диаметртэй тойрог багтаахаар хангалттай хэмжээтэй байна. Гэхдээ D хэмжээг нисдэг тэрэгний сэнс эргэж байх үеийн хамгийн их хэмжээ гэж тооцох хэрэгтэй.

3.3.3 Зэрэгцээ хоёр үндсэн сэнстэй нисдэг тэрэг аль ч талаас буух нөхцөлд БХБ нь сэнсний урд талаас хойд хитэг хүртэлх зайг 0.9 дахин үржүүлсэнээс багагүй диаметр бүхий тойрог багтаахаар хангалттай хэмжээтэй талбайтай байна. хэрэв эдгээр шаардлагуудыг хангах боломжгүй бол БХБ тэгш өнцөгт хэлбэртэй байж болох ба богино тал нь $0.75D$ -аас багагүй урт тал нь $0.9D$ -аас багагүй хэмжээтэй байх ба хоёр чиглэлээс буух үед $0.9D$ хэмжээтэй талаас нь оролт хийхээр төлөвлөх хэрэгтэй.

3.3.4 БХБ -ийн хязгаар дотор хэврэг байдлын шаардлага хангаж тогтоосон тухайн гүйцэтгэж буй үүргээсээ шалтгаалж тэнд байрлах шаардлагатайгаас бусад бэхлэгдсэн, хөдөлгөөнгүй объект байхыг хориглоно.

3.3.5 Тухайн гүйцэтгэж буй үүргээсээ шалтгаалж БХБ -ийн хязгаар дотор байрлах шаардлагатай объектууд 250 мм-ээс ихгүй өндөртэй байхыг зөвшөөрнө.

3.3.6 БХБ-ийн гадаргуу нисдэг тэрэг болон хүмүүс аль алинд нь хальтиргаа үүсэхээргүй байх ба шингэн тогтохоос сэргийлсэн налуутай байна. Хэрэв нисдэг тэрэгний тавцан хэлхэгдсэн бүтээц дээр баригдсан бол суурь бүтээц доод тавцан нь газрын нөлөө буурахгүй байхаар төлөвлөгдсөн байна.

3.3.7 Өргөгдсөн хэлипорттой адил гарц, будагны өнгө, аюулгүй торны шаардлагуудыг нисдэг тэрэгний тавцангийн хувьд хэрэгжүүлэх хэрэгтэй.

- Даацад тавигдах шаардлагууд

3.3.8 Буулт үйлдэх үеийн ачаалал

Тавцан дараах ачааллыг даах чадвартай төлөвлөгдсөн байна.:

(а) Дугуйтай хөл анги бүхий нисдэг тэрэгний хувьд хамгийн хүнд нисдэг тэрэгний нийт жингийн 75 хувьтай тэнцэх ачааг суух үндсэн хөл ангийн дугуйны эсхүл дугуйнуудын хүрэлцэх талбайд даах чадварыг, эсхүл

(b) Дугуйгүй, чаргатай хөл анги бүхий нисдэг тэрэгний хувьд хамгийн хүнд жинтэй нисдэг тэрэгний бүрэн ачаалсан жингээс 1.5 дахин илүү жинг даах чадвар.

Хэрэв үндсэн дугуйны хүрэлцэх талбай нь тодорхой бус байвал 300 мм х 300 мм хэмжээтэй талбай гэж тооцож хэрэглэж болно.

3.4. Хөлөг онгоц дээрх хэлипорт

3.4.1 Хэрэв нисдэг тэрэг үйл ажиллагаа явуулах талбай нь усан онгоцны хошуу эсхүл хитэг хэсэгт эсхүл хөлөг онгоцны бүтээц дээр зориулалтаар баригдсан бол нисдэг тэрэгний тавцан гэж тооцох ба 3.3 -р зүйлд заасан шаардлагууд хамаарна.

- Буух болон хөөрөх бүс ба Газардах болон Хөөрөх бүс

Хөлөг онгоцны бусад хэсгүүдэд байрших хэлипортын хувьд БХБ ба ГХБ давхацсан байж болно.

3.4.2 Хөлөг онгоцны хэлипортын хувьд хамгийн багадаа нэг БХБ-той байна.

3.4.3 Хөлөг онгоцны хэлипортын БХБ нь тойрог хэлбэртэй байх ба тухайн хэлипортыг ашиглах хамгийн том нисдэг тэрэгний D хэмжээнээс багагүй диаметртэй талбайг багтаах хангалттай хэмжээтэй байна. Гэхдээ D хэмжээг нисдэг тэрэгний сэнс эргэж байх үеийн хамгийн их хэмжээ гэж тооцох хэрэгтэй.

3.4.4 БХБ-ийн гадаргуу нисдэг тэрэг болон хүмүүсийн алинд нь ч хальтиргаа үүсгэхээргүй байна.

3.4.5 Хөлөг онгоцны хэлипортын хувьд 3.3.8 -р зүйлд шаардсан нисдэг тэрэгний тавцангийн даацтай ижил үзүүлэлттэй байна.

Дөрөвдүгээр бүлэг - Саадыг хязгаарлах ба арилгах

Энэ бүлэгт хэлипорт орчмын нисдэг тэрэгний нислэгийн үйл ажиллагааг аюулгүй явуулж болоход чиглэгдсэн саадаас чөлөөтэй байлгах агаарын зайг тогтоох шаардлагуудыг оруулсан.

Зураг 4-1-г үз.

4.1. Саадыг хязгаарлах гадаргуу ба сектор

- Ойртолтын ба хөөрөлтийн гадаргуу

4.1.1 Хэлипорт нь нисдэг тэрэг салхитай үед суулт эсхүл хөөрөлт үйлдэх боломжтой байхыг бататгасан хангалттай ойртолтын болон хөөрөлтийн налуу гадаргуутай байх хэрэгтэй.

4.1.2 Ойртолтын болон хөөрөлтийн налуу гадаргууд дараах шаардлагууд тавигдана.

Үүнд:

(a) Аюулгүй бүсийн хязгаараас цааш үргэлжилнэ.

(b) Аль ч тал руугаа БХБ-ны өргөн эсхүл диаметрийн урт дээр аюулгүй бүсийн хэмжээг нэмсэнтэй тэнцүү хэмжээтэй дотоод хязгаартай байна.

(с) Өдрийн цагаар үйл ажиллагаа явуулдаг Хэлипортын хувьд гадаргуугийн талууд нь 1:10 харьцаагаар ташуулдан сэнсний диаметрээс 7 дахин өргөн болтол өргөсч, цааш параллель болж үргэлжилнэ.

(d) Шөнийн цагаар үйл ажиллагаа явуулдаг Хэлипортын хувьд гадаргуугийн талууд нь 1:6.66 харьцаагаар ташуулдан сэнсний диаметрээс 10 дахин өргөн болтол өргөсч, цааш параллель болж үргэлжилнэ.

(e) саадаас чөлөөтэй гадаргуугийн налуу 1:8 харьцаанаас ихгүй байна.

(f) дотоод хязгаараас дээш 1220 метр өндөртэй болмогц тэгш гадаргуутай болж дуусна.

(g) Эргэлттэй нислэг үйлдэх траекторитой үед дараах шаардлагуудыг хангасан байна.Үүнд:

(i) дотоод хязгаарын өндрөөс дээш 30 м-ээс бага өндөрт эргэлт хийхгүй байх,

(ii) 120 градусаас илүү өнцгөөр эргэлт хийхгүй байх,

(iii) эргэлтийн радиус тэнхлэг шугам дээр 270 метрээс багагүй байх

- Аюулгүй ажиллагаа

4.1.3 Хэлипортын аюулгүй ажиллагааны үндсэн шаардлага бол ИНД-139.309(с)(3) ийн шаардлагыг хангасан ойртолт ба хөөрөлтийн тохиромжтой налуу гадаргуутай байх явдал юм. Энэ дүрмийн заалт хэрэв 1-р ангиллын хүчин чадалгүй нисдэг тэрэг бол газар дээрх аливаа хүнд ямар нэгэн зохисгүй эрсдэл учруулахгүйгээр авторотацийн буулт үйлдэж болохоор ойртолт ба хөөрөлтийн траекторыг сонгосон байна.

4.1.4 Хэлипортын ойртолтын ба хөөрөлтийн үеийн траектори нь нисдэг тэрэгний нисэх өндөр ба авторотацийн үзүүлэлтийг хангасан, онцгой байдлын үед саадаас дээш өнгөрч суулт үйлдэх боломжийг бүрдүүлсэн байна. Усны эсхүл газрын гадаргуу дээрхи ойртолтын ба хөөрөлтийн хамгийн тохиромжтой нөхцөл бол тухай бүрд гуравдагч оролцогч хамгийн бага саадтай байх явдал юм. Ойртолтын ба хөөрөлтийн үеийн траектори суурьшлын эсхүл үйлдвэрлэлийн бүс, тоглоомын талбай, автомашины зогсоол эсхүл хүн амын нягтрал ихтэй газрын дээгүүр гарахаас зайлсхийх нь чухал байдаг.

- Нисдэг тэрэгний тавцангууд ба хөлөг онгоцны хэлипорт

4.1.5 Нисдэг тэрэгний тавцан хамгийн багадаа 210 градусын саадаас чөлөөтэй ойртолтын ба хөөрөлтийн налуу сектор болон 150 градусын хязгаарлагдмал саадын сектортой байна.

4.1.6 Саадын хязгаартай сектор хөөрөлтийн дараа өндөр авах секторт хамаарахгүй хэсэгт БХБ -н захаас гадагшаа чиглэлд нисдэг тэрэгний нийт уртын гуравны нэгээс


багагүй зайд уртасч үргэлжилнэ. Тухайн секторын дотор 1:2 налуугаас дээшхи аливаа саад байхыг хориглоно. Зураг 4-2 -г үз.

- Хөлөг онгоц дундах хэлипорт


4.1.7 Хөлөг онгоцны тавцангийн дунд хэсэгт байрлах хэлипорт нь саадаас чөлөөтэй хоёр талаасаа буулт хөөрөлт үйлдэх боломж бүхий гадаргуутай байх ба ойртолтын болон хөөрөлтийн дараа өндөр авах гадаргуугийн хязгаарууд, БХБ -ын захаас үргэлжлэх саадын хязгаартай сектортой байна. Зураг 4-3 -г үз.

4.1.8 Саадын хязгаартай сектор нь тухайн хэлипортыг ашиглах хамгийн том нисдэг тэрэгний уртаас багагүй зайд гадагшаа чиглэлтэй үргэлжилнэ. Энэ секторын хүрээнд 1:5 налуугаас дээш хэсэгт аливаа саад байхыг хориглоно.


Нисдэг тэрэгний тавцангууд, хөлөг онгоцны хэлипортын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ИКАО Аннекс 14 2-р боть, “ Хэлипортууд” -аас авна уу.



Зураг 4-1. Ойртолт болон хөөрөлтийн траекторын тооцоо



Зураг 4-2. Үндсэн нэг сэнс болон зэрэгцээ хос сэнстэй нисдэг тэрэгнүүдэд зориулсан тавцангийн саадыг хязгаарлах секторууд



Зураг

4-3. Хөлөг онгоц дундах зориулж бариагүй хэлипортын саадын хязгаарлалтын гадаргуунууд

Тавдугаар бүлэг - Ил харааны тэмдэгтүүд

5.1. Салхины чиглэл заагч

Хэрэглээ

5.1.1 Хэлипорт дээр гадаргуун салхины чиглэлийг үнэлэх, тодорхойлох БХБ-д ойртож байгаа нисдэг тэрэгний нисгэх багт харагдаж байх салхи заагчтай байна.

5.2. Тэмдэгт ба тэмдэглэгээ - Хэлипортыг таних будган тэмдэглэгээ

Хэрэглээ

5.2.1 Хэлипортыг таних будган тэмдэглэгээг эмнэлгийн, өндрийн хэлипортууд, нисдэг тэрэгний тавцангууд, хөлөг онгоцны хэлипортуудад хийсэн байна.

Байрлал

5.2.2 Хэлипортыг таних будган тэмдэглэгээг шүргэх цэгийн тэмдэглэгээн дотор хийх ба эсхүл шүргэх цэгийн тэмдэглэгээ хийгдээгүй бол ГХБ-ны хэмжээнд хийсэн байна.

Онцлог

5.2.3 Эмнэлэг дээрх хэлипортоос бусад хэлипортын хувьд хэлипортыг таних будган тэмдэглэгээ нь цагаан өнгийн **H** үсэг байна.


5.2.4 Эмнэлэг дээрх хэлипортыг тодорхойлох будган тэмдэглэгээ нь цагаан өнгийн загалмай тэмдэглэгээ дээр хийгдсэн улаан өнгийн **H** үсэг байна.

5.2.5 Хэлипортыг таних будган тэмдэглэгээ нь H үсэгний хөндлөвч нь тохиромжтой төгсгөлийн ойртолт хийх чиглэлтэй зөв өнцөг үүсгэж байхаар байрласан байна.


Тэмдэглэгээний хэмжээг зураг 5-1(a)-аас үз.

ГХБ-ны хэмжээ 9 метр x 9 метр-ээс бага бол цагаан загалмайн талуудын хэмжээг тэнцүү бус масштабаар болон H үсэгний өндрийг багасгаж болох ба H үсэгний өндөр багадаа 2.8 метр хэмжээтэй байна. Зураг 5-1(b)-г үз.

Олсон тороор бүрхэгдсэн нисдэг тэрэгний тавцангуудын хувьд уг хэмжээг 3 м -ээс 4 м хүртэл томосгож бусад хэмжээг пропорциональ хэмжээгээр томосгож хийвэл илүү сайн харагдагддагтай байж болох юм.



Зураг 5-1(а). Ойртолт үйлдэж байх үед танигдахаар эмнэлгийн загалмай бүхий хэлипортын таних тэмдэглэгээ.



Зураг 5-1(б). 9 x 9 метрээс бага хэмжээтэй ГХБ бүхий эмнэлгийн хэлипортын пропорцгүй загалмай болон таних тэмдэглэгээ

- Зөвшөөрөгдөх хамгийн их жингийн тэмдэглэгээ

Хэрэглээ

5.2.6 Өргөгдсөн түвшний хэлипорт болон нисдэг тэрэгний тавцангуудад зөвшөөрөгдөх хамгийн их жингийн тэмдэглэгээ хийгдсэн байна.

Байрлал

5.2.7 Зөвшөөрөгдөх хамгийн их жингийн тэмдэглэгээг ГХБ дээр тохиромжтой сүүлийн ойртолт хийх чиглэлээс уншигдаж байхаар хийсэн байна.

Онцлог

5.2.8 Зөвшөөрөгдөх хамгийн их жингийн тэмдэглэгээг 2 оронтой тооны дараа жижиг t үсэг байхаар тэмдэглэх ба энэ нь нисдэг тэрэгний зөвшөөрөгдсөн жинг тонноор үзүүлсэн тэмдэглэгээ байна.

5.2.9 Энэ тоонууд ба үсгийг зураг 5-2-д үзүүлсэн загвар, харьцаатайгаар цагаан

өнгөөр хийсэн байна.

- БХБ-ны тэмдэглэгээ эсхүл тэмдэгт

Хэрэглээ

5.2.10 БХБ -г өргөсгөх нь тодорхой биш газрын түвшингийн хэлипортын БХБ- бүсийг тодорхой харагдуулах тэмдэглэгээ эсхүл тэмдэгттэй байна.

Байрлал

5.2.11 БХБ-ны тэмдэглэгээ эсхүл хавтгай тэмдэгтийг түүний хүрээ хязгаар дээгүүр тэмдэглэх буюу байрлуулна.

Онцлог

5.2.12 Хучилттай гадаргуу дээр будган тэмдэглэгээг 600 мм-ийн өргөнтэй, үргэлжилсэн цагаан шугамаар хийнэ. БХБ-нь зүлгэн гадаргуутай бол өвсийг хадах замаар тойрог хүрээ тэмдэглэгээ ялгарч тодорхой байхаар, хэрэв өвсгүй хатуу шороон гадаргуу бол тохиромжтой цагаан тэмдэгт самбараар эсхүл өөр ялгарах зүйлээр хийж тэмдэглэнэ.




Figure 5-2. Forms and proportion of numbers and letter for maximum allowable mass marking

Зураг 5-2. Хэлипортын зөвшөөрөгдсөн хамгийн их жингийн тоо ба үсэгний загвар, харьцаа

- Шүргэх цэгийн тэмдэглэгээ

Хэрэглээ


5.2.13 ГХБ-аас тодорхой зайтай цэг дээр суулт үйлдэх эсхүл тэр цэгээс хөөрөлт үйлдэхэд нисэх багт зайлшгүй шаардлагатай хэлипортод шүргэх цэгийн тэмдэглэгээг хийнэ.

Байрлал

5.2.14 Шүргэх цэгийн тэмдэглэгээ нь БХБ-н хүрээнд байрласан байна.

Онцлог

5.2.15 Шүргэх цэгийн тэмдэглэгээ нь зөв гурвалжин байх ба түүний нэг оройн өнцөг нь тохиромжтой ойртолтын чиглэлтэй давхцахаар байрласан байна. Энэ тэмдэглэгээ нь цагаан өнгийн үргэлжилсэн шугам байх ба зай хэмжээ зураг 5-3-үзүүлсэнтэй нийцэж



байна.

Зураг 5-3. Шүргэх цэгийн тэмдэглэгээ

- ГХБ-ны тэмдэглэгээ*Хэрэглээ*

5.2.16 ГХБ-ны тэмдэглэгээг өндрийн хэлипорт, нисдэг тэрэгний тавцан болон хэрэв ГХБ-ийн периметр ялгагдахгүй хэлипорт дээр хийнэ.

Байрлал

5.2.17 ГХБ-ны тэмдэглэгээ нь ГХБ-н периметрийг хүрээлж байрлана.

Онцлог

5.2.18 ГХБ-ны тэмдэглэгээ нь багадаа 300 мм-ийн өргөнтэй үргэлжилсэн цагаан шугам байна.

- Газардах хэсгийн тэмдэглэгээ*Хэрэглээ*

5.2.19 Тухайн байрлалд нисдэг тэрэг газардах зайлшгүй шаардлагатай бол газардах хэсэг тэмдэглэгээтэй байна.

Байрлал

5.2.20 Газардах хэсгийн тэмдэглэгээний дээр нисдэг тэрэг зогсоход нисдэг тэрэгний хэвтээ том сэнс ба аливаа бэхэлгээтэй саадын (барилга, ангар, антенн гэх мэт) хооронд сэнсний диаметрийн хагасаас багагүй зайтай байхаар газардах хэсэг тэмдэглэгээ байрласан байна.

Онцлог

5.2.21 Газардах хэсгийн тэмдэглэгээ нь тохиромжтой диаметр бүхий шар өнгөтэй тойрог байх ба шугамын өргөн хамгийн багадаа 500 мм, эсхүл нисдэг тэрэгний тавцан дээр 1000 мм өргөнтэй байна.

- Хэлипортын нэрний тэмдэглэгээ*Хэрэглээ*

5.2.22 Ил хараагаар танихад хангалттай биш хэлипортын нэрийг тэмдэглэсэн байна.

Байрлал

5.2.23 Хэлипортын нэрний тэмдэглэгээг хэвтээ гадаргуугаас дээш ямар ч өнцгөөс аль болох холоос харагдаж байхаар хэлипорт дээр тэмдэглэсэн байна. Саадтай сектор байгаа тохиолдолд Н үсэг бүхий таних тэмдэглэгээний саадтай талд нь тэмдэглэгээг хийнэ.

Онцлог

5.2.24 Хэлипортын нэрний тэмдэглэгээ нь түүний нэр эсхүл таних тэмдгийг

агуулсан байх эсхүл нэр, таних тэмдгийг хамтад нь үзүүлсэн байж болно. Тэмдэглэгээний тэмдэгтийн өндөр газрын түвшний хэлипортын хувьд 300 см-ээс багагүй, өргөгдсөн түвшний хэлипортын хувьд 120 см-ээс багагүй байна. Тэмдэглэгээний өнгө дэвсгэр өнгөнөөс ялгаатай харагдахаар байна.

- Аюулгүй бүсийн тэмдэглэгээ

5.2.25 Олон нийт тээврийн хэрэгслээр эсхүл явган хүний замаар шууд холбогдох газарт Хэлипорт байрласан бол аюулгүй бүсийн гадна хязгаарыг хаалт тэмдэгт тавьж нисдэг тэрэгний үйл ажиллагаанд холбогдолгүй тээврийн хэрэгсэл эсхүл явган хүнийг санамсаргүй нэвтрэхээс сэргийлсэн байна.

- Агаараар явгалах зурвасны тэмдэгтүүд

Хэрэглээ


5.2.26 Агаараар явгалах зурвасыг зайлшгүй тэмдэглэх шаардлагатай бол агаараар явгалах зурвасын тэмдэгтүүдийг ашиглан тэмдэгжүүлсэн байна.

Байрлал

5.2.27 Агаараар явгалах замын тэмдэгтүүдийг агаараар явгалах замын тэнхлэгийн дагуу чиг шулуун хэсэгтээ хоорондын зай нь 30 метр, эргэлттэй хэсэгт 15 метрээс ихгүй байхаар байрлуулсан байна.

Онцлог

5.2.28 Агаараар явгалах замын тэмдэгт нь хэврэг материалаар хийгдсэн байх ба суурилагдсан үедээ гадаргуугийн эсхүл цасны түвшнээс дээш 350 мм-ээс ихгүй өндөртэй байна. Тэмдэгтийн гадаргууг нисгэгч дээрээс харахад тэгш өнцөгт хэлбэртэй, харагдах хамгийн бага талбай нь 15000 мм²-аас багагүй хэмжээтэй, зураг 5-4 -д үзүүлсэны дагуу өндрийг өргөнд харьцуулсан харьцаа нь ойролцоогоор 3:1 хэмжээтэй байна.



Зураг 5-4. Агаараар явгалах зурвасны тэмдэгт

5.3. Гэрлүүд - Салхи заагч

5.3.1 Шөнийн цагаар ашиглах хэлипорт нь гадна талбай, байшингийн гэрэлтүүлэгтэй байх ба гэрэлтэй салхи заагч эсхүл ямар нэг өөр арга хэрэглэн гадаргуугийн салхины чиглэл ба хурдыг байнга тодорхойлох боломжтой тоноглолтой байна.

- Хэлипортын маяк

Хэрэглээ

5.3.2 Хүрээлэн байгаа гэрлүүдээс эсхүл өөр бусад шалтгаанаар олоход хүндрэлтэй байдаг хэлипорт дээр хэлипортын маягыг байрлуулсан байна.

Байрлал

5.3.3 Хэлипортын маяк нь хэлипорт дээр эсхүл залгаа байршилд өндөрсгөж байрласан байх нь тохиромжтой ба нисэх багийг ойрын зайд гялбуулахааргүй байх шаардлагатай.


Онцлог

5.3.4 Хэлипортын маягийн шаардлагууд ИКАО-ийн Хавсралт 14-ийн 2 р боть болох “Хэлипортууд” хэсгийн 5-р бүлэг, 5.3.2-р зүйлд тусгагдсан болно.


- БХБ-ны гэрэл

Хэрэглээ


5.3.5 Газрын түвшингийн хэлипортыг шөнийн цагаар ашигладаг бол БХБ-г гэрэлтүүлсэн байна. Харин БХБ -хэмжээ нь тодорхой нөхцөлд эсхүл БХБ ба ГХБ давхцсан бол ГХБ-г гэрэлтүүлсэн байна.



Зураг 5-5. Хэлипортын маякны анивчих онцлог



Зураг 5-6(а). Эмнэлгийн хэлипортийн тэмдэглэгээ



Зураг 5-6(б). Өргөгдсөн түвшний хэлипорт

Байрлал

5.3.6 БХБ-ны хязгаарын дагуу гэрлүүдийг хоорондоо ижил зайтай байхаар байрлуулсан байна. Зураг 5-6 (а) ба 5-6(б)-г үз.

(а) квадрат эсхүл тэгш өнцөгт хэлбэртэй талбайн тал бүр дээр багадаа 4 гэрлийг булангийн гэрэлтэй хамт хоорондын зай нь 5000 мм-ээс ихгүй байхаар байрлуулна,

(b) квадрат эсвэл тэгш өнцөгт хэлбэртэй талбайгаас өөр хэлбэртэй талбай, мөн тойрог хэлбэртэй талбайн хувьд багадаа 10 гэрлийг хоорондын зай нь 5000 мм-ээс ихгүй байхаар байрлуулсан байна.

Онцлог

5.3.7 БХБ-ны гэрлүүд нь шар юмуу хөх өнгөтэй, олон чиглэлийн тусгалтай

гэрлүүд байна. Булангийн гэрлүүд шар өнгөтэй байх ба энэ гэрлүүдийн өнгө хэлбэр нь нь нисэх баг БХБ-г эргэн тойрны бусад гэрлүүдийн дундаас эргэлзэлгүй таних зорилготой байна.

5.3.8 Нөөцлөгдсөн

- ГХБ-ын гэрэл

Хэрэглээ

5.3.9 Шөнийн цагаар ашиглах хэлипортын ГХБ-г гэрлийн системээр тоногловсон байна.

5.3.10 Газрын түвшний хэлипортын ГХБ-н гэрлийн систем дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

(a) талбайн периметрийн гэрлүүд, эсхүл

(b) прожектор эсхүл периметрийн ба прожектор гэрлээр аль алинаар нь тоногловсон байна.

5.3.11 Зөвхөн хүрээлэн байгаа орчны гэрлүүдээс шалтгаалж нисэх баг хэлипортыг ялгаж таних боломжгүй байж болох тохиолдолд талбайн периметрийн гэрлүүд суурилуулсан байх шаардлагатай.

5.3.12 Өргөгдсөн түвшний хэлипорт эсхүл нисдэг тэрэгний тавцангийн ГХБ-н гэрлийн систем дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

(a) талбайн периметрийн гэрлүүд ба,

(b) прожектор

Байршил

5.3.13 ГХБ-ны периметрийн гэрлүүд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

(a) ГХБ-ны хязгаарын дагуу эсхүл хязгаараас 1500 мм-ийн зай дотор, эсхүл,

(b) өргөгдсөн түвшний хэлипортын ашиглаж болох талбайн хязгаар дээгүүр гэрлүүдийг байрлуулна. *(Энэ талбай нь БХБ-гаас бага байж болох ба ГХБ-г тойруулан түүний хязгаараас 1500 мм-ээс багагүй зайнд байрласан байна.)*

(c) ГХБ нь тойрог хэлбэртэй бол талбайн хэлбэрийг нисэх багт ойлгогдохоор харуулах зорилгоор гэрлүүдийг шулуун шугам дээр байрлуулсан байна.

5.3.14 ГХБ-ны периметрийн гэрлүүдийг өндрийн хэлипорт болон нисдэг тэрэгний тавцангийн хувьд 3000 мм, газрын түвшний хэлипортын хувьд 5000 мм-ээс ихгүй хоорондоо жигд зайтай байрлуулсан байна.

ГХБ-ны периметрийн гэрлүүд нь багадаа 8 ширхэг талбайн тал бүр дээр булангийн гэрлийг оролцуулаад багадаа 3 гэрэл байхаар байрлуулсан байна.

5.3.15 Өргөгдсөн түвшний хэлипорт эсхүл хөдөлгөөнгүй нисдэг тэрэгний тавцан дээр ГХБ -н периметрийн гэрлүүд ГХБ -н өндрөөс нам өндөрт байгаа нисгэгчид талбайн хэлбэр дүрс харагдахгүй байхаар суурилагдах ёстой.

5.3.16 Хөвөгч нисдэг тэрэгний тавцан дээр ГХБ -н периметрийн гэрлүүд ГХБ -н өндрөөс нам өндөрт байгаа нисгэгчид талбайн хэлбэр дүрс харагдахгүй байхаар суурилагдах ёстой.

5.3.17 ГХБ -н прожекторууд нислэг үйлдэж буй нисэгчдийн нүдийг гялбуулахгүй эсхүл талбай дээр ажиллаж байгаа ажилтнуудыг гялбуулахгүй байх шаардлагатай. Прожекторуудын гэрлийн тусгал нь сүүдэр хамгийн бага байх нөхцлийг хангасан байна.

Онцлог

5.3.18 ГХБ-ны периметрийн гэрлүүд нь олон чиглэлийн тусгалтай, шар өнгөтэй, бэхлэгдсэн гэрлүүд байна.

5.3.19 ГХБ-ны периметрийн гэрлүүд нь 250 мм-ээс ихгүй өндөртэй байх ба хэрэв гадаргуугаас дээш гарсан эдгээр гэрлүүд нисдэг тэрэгний үйл ажиллагаанд аюултай бол хучилтанд суулгасан байдлаар хийнэ.

5.3.20 ГХБ-ны прожектор маягийн гэрлүүдийг талбайн периметр дагуу байрлуулсан бол 250 мм-ээс ихгүй өндөртэй байхаар хийнэ.

5.3.21 ГХБ-ны прожектор маягийн гэрлүүдийн өнгөнүүд нь Хэлипортын гадаргуу ба саадын тэмдэглэгээнүүд зөв танигдахаар хийгдсэн байна.

- Шүргэх цэгийн гэрэл

Хэрэглээ

5.3.21 Шөнийн цагаар ашиглагддаг хэлипортд шүргэх цэгийг тогтоосон бол шүргэх цэгийн гэрэл хийсэн байна.

Байрлал

5.3.22 Шүргэх цэгийн гэрэл нь шүргэх цэгийн тэмдэглэгээтэй хамт байрлана.

Онцлог

5.3.23 Зураг 5-7-д үзүүлсний адилаар байрласан шүргэх цэгийн гэрэл нь багадаа 6 ширхэг, олон чиглэлийн тусгалтай, цагаан өнгөтэй гэрэл байна. Нисдэг тэрэгний үйл ажиллагаанд аюулгүй байх зорилгоор эдгээр гэрлүүдийг хучилтын түвшинд суулгаж байрлуулсан байна.


- Агаараар явгалах зам

5.3.24 Агаараар явгалах замын тэнхлэгийн хоёр чиглэлийн тусгалтай шар өнгийн гэрлээр эсхүл прожектороор хангалттай гэрэлтүүлсэн байна.

- Саадыг гэрэлтүүлэх

5.3.25 Хэлипортын орчимд байрласан үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа саадыг улаан өнгийн саадын гэрлээр тэмдэглэсэн байх эсхүл гэрэлтүүлэг 10

cd/m²-ээс багагүй боловч нисэх багийг гялбуулахгүй байхаар тохируулагдсан прожектороор гэрэлтүүлсэн байна.



Зураг 5-7. Шүргэх цэгийн гэрэл

Зургадугаар бүлэг - Эмнэлгийн хелипорт

Эмнэлгийн хелипорт эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай хүнийг хүргэх эсхүл өвчтөнийг шилжүүлэх үед эмнэлгийн хүндрэл гаргахаас сэргийлэх зайлшгүй шаардлагаар эмнэлгийн газартай ойр орчимд байрладаг. Энэ нөхцлийг хүлээн зөвшөөрч зарим эмнэлгийн газар ба байгууламж эрт баригдсан, удаан хугацаанд оршин байгаа бол, эмнэлгийн хелипортын дизайны стандарт шаардлагыг дараахи маягаар багасгах боломжтой.

6.1. Аюулгүй бүс

6.1 Хэрэв төгсгөлийн ойртолт хийх БХБ -г эргэн тойрны 3000 мм аюулгүйн талбайн хамт хангах боломжгүй бол, аюулгүйн талбай байхгүй байж болно. Саадаас чөлөөтэй гадаргуунууд ба объект хүртэлх зайнуудыг төгсгөлийн ойртолт хийх БХБ -ийн хязгаараас тооцно.

Хавсралт 1

Монгол Улсад ашиглагдаж болох нисдэг тэрэгний жин, хэмжээ ба БХБ/ГХБ-н хэмжээнүүд

Хавсралт 1

Weight, dimensions and resulting БХБ/ГХБ sizes for some helicopters

Нисдэг тэрэгний загварууд	Хөөрөх хамгийн их жин (кг)	Сэнсний диаметр (m)	Нийт урт (m)	Чарганы урт (m)	Чарганы өргөн (m)	Минимум хэмжээнүүд		
						БХБ (m)	Аюулгүй бүс (m)	ГХБ (m)
Sikorski S-55	3583	16.18	19.0	3.2	3.35	28.5	4.8	5.3
S-58T	6169	17.07	20.06	8.61	3.66	30.09	5.1	5.5
S-61	9980	18.9	22.14	7.16	3.96	33.21	5.6	6.0
Bell UH-1D/H	4309	14.63	17.40	3.68	2.84	26.1	4.6	5.6
Bell 47G	1338	11.30	13.15	3.00	2.30	20	3.8	4.5
Bell 205	4309	14.63	17.40	3.08	2.84	26.1	4.6	5.6

Энэ хүснэгт мэдээллийн чанартай болно. Нисдэг тэрэгний төрөл загвараас шалтгаалж өөр жин, хэмжээтэй байж болно.